

Барилга, хот байгуулалтын сайдын 2015оны 12 дугаар сарын 17-ны өдрийн  
246 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## **“ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН КАДАСТРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ОЛГОХ ЖУРАМ”**

### **Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү журмын зорилго нь Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага /цаашид “мэргэжлийн байгууллага” гэх/-ын эрхийг олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, гэрчилгээг нөхөн олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журам нь дараах хавсралттай байна.

1.2.1.Мэргэжлийн байгууллагын суурь нөхцөл шаардлага /нэгдүгээр хавсралт/;

1.2.2.Аж ахуйн нэгжээс ирүүлэх өргөдлийн загвар /хоёрдугаар хавсралт/;

1.2.3.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчтэй байгуулах гэрээний загвар /гуравдугаар хавсралт/;

1.2.4.Мэргэжлийн байгууллагын гэрчилгээний загвар /дөрөвдүгээр хавсралт/;

1.2.5.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчийн тайлангийн загвар /тавдугаар хавсралт/;

1.2.6.Гэрээ дүгнэсэн тэмдэглэлийн загвар /зургаадугаар хавсралт/.

1.3.Журмын нэгдүгээр хавсралтад заасан суурь нөхцөл шаардлагыг хангасан, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.5 дахь заалтад хамаарах Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжид холбогдох заалтаар мэргэжлийн байгууллагын эрхийг олгоно.

1.4.Мэргэжлийн байгууллагын эрхийг олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, гэрчилгээг нөхөн олгох талаар урьдчилсан дүгнэлт гаргах үүрэг бүхий комисс /цаашид “комисс” гэх/-ийг Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр /цаашид “Сайдын тушаал” гэх/-ээр байгуулна.

1.5.Комиссын дүгнэлтийг үндэслэн Сайдын тушаалаар мэргэжлийн байгууллагын эрхийг олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, гэрчилгээг нөхөн олгох асуудлыг шийдвэрлэнэ.

1.6.Комиссын ахлагч, нарийн бичгийн дарга нь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл бүхий 5-аас доошгүй гишүүнтэй байна. Комисст салбарын төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

1.7. Мэргэжлийн байгууллагын эрхийг дараах заалтаар олгоно.

1.7.1.Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа,газрын нөхөн сэргээлт хийх;

1.7.2.Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх;

1.7.3. Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх.

1.8.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, холбогдох хууль болон энэ журамд нийцүүлэн зохих арга хэмжээг авч ажиллана.

## **Хоёр. МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ АВАХ, ХУГАЦААГ СУНГАХ ХҮСЭЛТ ГАРГАХ, БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

2.1.Хүсэлтийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр гаргах эсвэл албан ёсны цахим шуудангаар илгээж болно.

2.2.Аж ахуйн нэгж нь мэргэжлийн байгууллагын эрх шинээр авах, хугацааг сунгуулах хүсэлтээ гаргахдаа энэхүү журмын 2.5,2.6-д заасан бичиг баримтыг хоёрдугаар хавсралтын дагуу үнэн зөв бүрдүүлнэ.

2.3.Энэхүү журмын 2.5.1-2.5.4-т заасан бичиг баримтыг сүүлийн 6 сарын дотор нотариатаар баталгаажуулсан байна.

2.4.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусахаас хуанлын 30 ба түүнээс доошгүй өдрийн өмнө сунгуулах хүсэлтээ, гэрээ дүгнэсэн тэмдэглэлийн хамт Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Дурдсан хугацаанд хүсэлтээ ирүүлээгүй тохиолдолд шинээр авах хүсэлт гаргана.

2.5.Мэргэжлийн байгууллагын эрхавахад бүрдүүлэх баримт бичиг

2.5.1.аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм

2.5.2.инженер, техникийн ажилтан тус бүрийн диплом, иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэр;

2.5.3.зөвлөх болон мэргэшсэн инженерийн мэргэшлийн зэргийн гэрчилгээ;

2.5.4. хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулгын гэрчилгээ;

2.5.5. үйл ажиллагаанд ашиглах норм норматив баримт бичгийн жагсаалт.

2.6. Мэргэжлийн байгууллагын эрхийн хугацааг сунгахад бүрдүүлэх баримт бичиг

2.6.1. Мэргэжлийн байгууллагын эрхийн хугацааг сунгуулах тухай хүсэлт;

2.6.2. Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчтэй байгуулсан гэрээг дүгнэсэн тэмдэглэл;

2.6.3. шинэчилсэн норм норматив баримт бичгийн жагсаалт.

## **Гурав. МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮСЭЛТИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**

3.1. Комисс нь аж ахуйн нэгжийн ирүүлсэн хүсэлтийг ажлын 18 өдрийн дотор хянан хэлэлцэж, урьдчилсан дүгнэлтээ Газрын эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.2. Энэ журмын 3.6, 5.2-т заасан нөхцөл үүссэн болтатгалзсан үндэслэлийг дурьдаж, ажлын 5 өдөрт багтаан албан бичгээр хариу мэдэгдэнэ.

3.3. Аж ахуйн нэгж нь мэргэжлийн байгууллагын гэрчилгээг гээсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн, ашиглах боломжгүй болсон болон бусад шалтгаанаар нөхөн олгох хүсэлт гаргасан бололтон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүчингүйд тооцох тухай зарлуулсан баримт болон нөхөн олгох талаар комиссын урьдчилсан дүгнэлтийг үндэслэн Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гэрчилгээг мэргэжлийн байгууллагын эрхийн хүчинтэй хугацаагаар нөхөн олгоно.

3.4. Аж ахуйн нэгжийн ирүүлсэн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэхээр бол шийдвэрлэх хугацааг 10 хүртэл өдрөөр сунгаж болно.

3.5. Мэргэжлийн байгууллагын эрхийг олгохдоо улс орны батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг баримтална.

3.6. Комисс нь дараах нөхцөл байдал үүссэн тухай урьдчилсан дүгнэлт гарсан бол энэ тухай аж ахуйн нэгжид мэдэгдсэнээс хойш 3 жилийн хугацаанд дахин хүсэлт хүлээн авч, хэлэлцэхгүй.

3.6.1. Мэргэжлийн байгууллагын эрх авах, сунгуулах хүсэлт гаргахдаа хуурамч гэрээ хэлцэл, бичиг баримт бүрдүүлсэн, эсхүл эрх бүхий байгууллагаас тогтоогдсон;

3.6.2. Энэхүү журмын 5.2-т заасан нөхцөл үүссэн.

3.7. Аж ахуйн нэгж нь гэрээний үүргээ 1 жил хүртэл хугацаанд хангалтгүй биелүүлсэн бол газрын хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн үйл ажиллагааг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

3.8. Мэргэжлийн байгууллагын эрх шинээр олгох, сунгах тухай Сайдын тушаал гарснаас хойш мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгох ажлыг ажлын 15 өдөрт багтаан зохион байгуулна.

### **Дөрөв. МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ОЛГОХ**

4.1. Мэргэжлийн байгууллагын эрхийг 3 жилийн хугацаатайгаар олгоно.

4.2. Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчтэй байгуулах гэрээнд дараах асуудлыг тусгана.

4.2.1. Олгогдсон эрхийн үйл ажиллагааны хүрээнд Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, норм дүрэм, нөхцөл шаардлагыг баримталж ажиллах;

4.2.2. Мэргэжлийн боловсон хүчин, хэмжилтийн багажны шилжилт, өөрчлөлтийг тухай бүр бүртгүүлэх.

4.3. Мэргэжлийн байгууллагын эрх олгогдсон тухай аж ахуйн нэгжид ирүүлсэн баримт бичиг дээрх цахим хаяг эсвэл утсаар нь мэдэгдэх ба гэрээ байгуулсны дараа олгогдсон эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

### **Тав. МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХИЙН ХУГАЦААГ СУНГАХ**

5.1. Мэргэжлийн байгууллагын эрхийг анх олгосон хугацаагаар сунгана.

5.2. Дараах нөхцөлд мэргэжлийн байгууллагын эрхийн хугацааг сунгахгүй. Үүнд:

5.2.1. 2 ба түүнээс дээш жилийн хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй

5.2.2. мэргэжлийн байгууллагын эрхийн хүчинтэй хугацаанд олгогдсон эрхийн хүрээнд ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй;

5.2.3. мэргэжлийн байгууллагын эрхийн суурь, нөхцөл шаардлагыг 2 ба түүнээс дээш жилийн хугацаанд зөрчиж ажилласан нь хяналт шалгалтаар тогтоогдсон.

### **Зургаа. МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ**

6.1.Мэргэжлийн байгууллага нь гүйцэтгэж буй ажилдаа алдаа, зөрчил гаргасны улмаас байгууллага, иргэн, аж ахуйн нэгжид цаг хугацааны болон мөнгөн хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол олгогдсон эрхийг түдгэлзүүлэх, сэргээх асуудлыг Газрын асуудал эрхэлсэн улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

## **Долоо.МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ**

7.1.Дараах нөхцөл байдал үүсвэл мэргэжлийн байгууллагын эрхийг хүчингүй болгоно. Үүнд:

7.1.1.Аж ахуйн нэгж татан буугдсан;

7.1.2.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигч хүсэлт гаргасан;

7.1.3.Мэргэжлийн байгууллагын эрх авах, хугацааг сунгуулахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

7.1.4.Мэргэжлийн байгууллагын эрхийн суурь нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

7.1.5.Газрын асуудал эрхэлсэн улсын байцаагчийн зөрчил арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

7.2.Мэргэжлийн байгууллагын эрхийг хүчингүй болгосон шийдвэрийн талаар тухайн аж ахуйн нэгж болон харьяалах татварын албанд ажлын 3 өдөрт багтаан бичгээр мэдэгдэж, албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

7.3.Мэргэжлийн байгууллагын эрхийг хүчингүй болгосон аж ахуйн нэгжээс дахин мэргэжлийн байгууллагын эрх авах хүсэлт хүлээн авахгүй.

## **Найм. БУСАД ЗҮЙЛ**

8.1.Мэргэжлийн байгууллагын эрх олгосон байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдгээрийн талаарх мэдээллийг шинэчлэх, баяжуулах, холбогдох өөрчлөлтийг хийх, мэдээллийн сангийн тасралтгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, байгууллага, иргэдийг мэдээллээр хангаж ажиллана.

8.2.Мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуйн нэгжийн мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байна.

8.3.Гэрчилгээг энэхүү журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу үйлдэнэ.

Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн

байгууллагын эрх олгох журмын нэгдүгээр хавсралт

Заалт	Заалт	Эрхлэх үйл ажиллагаа	Байвал зохих инженер техникийн ажилтан	Аж ахуйн нэгжийн өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж, программ хангамж
1	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, газрын нөхөн сэргээлт хийх,	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан	<p>1. Газар зохион байгуулагч инженер–1</p> <p>2. Газрын кадастрын инженер – 1 эсвэл газар зүйн мэдээллийн системийн инженер-1</p> <p>3. Хөрс судлаач-1</p> <p>4. Ургамал судлаач-1 эсвэл агрономич -1</p>	<p>1. Газрын нөхөн сэргээлт хийх машин механизм /бульдозер-1, автосамосвал-1/-тай, эсвэл бусадтай энэ чиглэлээр байгуулсан гэрээ</p> <p>2. Эрхэлж буй ажилтай холбоотой гарын авлага материалын жагсаалт</p> <p>3. Хөрсний PH, корроз болон бусад найрлага тодорхойлогч лаборатори-1 эсвэл бусадтай энэ чиглэлээр байгуулсан гэрээ</p>
2	Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх	Газрын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан	<p>1. Газар зохион байгуулагч инженер–2</p> <p>2. Газрын кадастрын инженер – 1</p> <p>Газар зохион байгуулагч инженерийн аль нэг нь мэргэшсэн зэрэгтэй байна.</p>	<p>1. Эрхэлж буй ажилтай холбоотой гарын авлага материалын жагсаалт</p>

3	Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх	Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан	1. Мэргэшсэн газар зохион байгуулагч инженер-1 2. Кадастрын инженер – 1 3. Хөрс судлаач – 1 4. Ургамал судлаач – 1 5. Газар зүйн мэдээллийн системийн эсвэл газарзүйч-1	1. Электрон тахеометр-1 эсвэл өндөр нарийвчлалын GNSS-ийн багаж-1 2. Эрхлэх ажилтай холбоотой гарын авлага материалын жагсаалт 3. Хөрсний PH, корроз болон бусад найрлага тодорхойлогч лаборатори-1 эсвэл бусадтай энэ чиглэлээр байгуулсан гэрээ 4. Хээрийн туршилтын багажууд/хөрсний дулааны горим хэмжигч-1, шүүрлийн коэффициент тодорхойлогч-1, газар хөдлөлийн балл тодорхойлогч-1, хөрсний физик механик шинж чанар тодорхойлогч-1/
---	--	---	---	--

Жич:

1.Хөрс судлаач, ургамал судлаач нь мэргэжлийн байгууллагын эрх бүхий 2 хүртэл ААН-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж болно.

Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох журмын хоёрдугаар хавсралт

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Огноо: .....оны .....дугаар сарын ...-ны өдөр

## МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ОЛГОХ/ СУНГАХЫГ

### ХҮССЭН ӨРГӨДӨЛ

*Заалт 1*

*Заалт 2*

.....  
Аж ахуйн нэгж байгууллагын нэр

.....Хуудас

УЛААНБААТАР

20.. он

Хүсэлтийн загвар

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН  
ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН ГАЗАРТ**

Мэргэжлийн байгууллагын эрх хүсэх сунгуулах тухай

Манай байгууллага нь газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг дараах заалтаараах /сунгуулах/ хүсэлтээ илэрхийлж байна. Үүнд:

- Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, газрын нөхөн сэргээлт хийх;
- Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх;
- Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх;

Тус эрхийг авахад бүрдүүлсэн бичиг баримт нь үнэн зөв бөгөөд шаардлагатай тохиолдолд тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрыг үзүүлэхэд бэлэн болно.

**Аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж:**

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/

гарын үсэг

Тэмдэг

Огноо

Байгууллагын албан ёсны хэвлэмэл хуудсыг ашиглах ба хэвлэмэл хуудас нь Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн тушаалаар батлагдсан “**ТӨРИЙН АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗААВАР**”-ын 2.3.3-2.3.4 дэх шаардлагыг хангасан байна.

### МАТЕРИАЛЫН БҮРДЭЛ

№	Нэр	Тэмдэглэл (√)
1	Албан бичиг	
3	Маягт №1, 2, 3,4,5	
4	Аж ахуйн нэгжийн дүрэм	
5	аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ	
6	Үндсэн ажилтан	Иргэний үнэмлэх
		Диплом
		Нийгмийн даатгалын дэвтэр
		Мэргэшсэн зэргийн гэрчилгээ
7	Гэрээт ажилтан	Иргэний үнэмлэх
		Диплом
		Хөдөлмөрийн гэрээ
8	Багаж баталгаажуулалтын гэрчилгээ	
9	Тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ	

Маягт №1

### МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ХҮСЭГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Оноосон нэр, өмчийн хэлбэр	
2	Аж ахуйн нэгжийн хэлбэр	
3	Улсын бүртгэлийн дугаар: Регистрийн дугаар:	

4	Энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа:	
5	Аж ахуйн нэгжийн албан ёсны хаяг:	
6	Шуудангийн хайрцаг, харилцах утас, факс, E-mail	
7	Харьяалагдах татварын алба /дүүрэг/	
8	Байгуулагдсан он:	

Тайлбар: Энэ маягтанд холбогдох мэдээллийг нотлох баримтуудыг хавсаргана.

Дарга /Захирал/ ..... /Овог нэр/

гарын үсэг

Тэмдэг

**Удирдах болон ИТА-ны тодорхойлолт**

<b>№</b>	<b>Овог нэр</b>	<b>Нас хүйс</b>	<b>Албан тушаал</b>	<b>Мэргэжил</b>	<b>Мэргэжилтний мэргэшлийн зэрэг</b>	<b>Тухайн салбарт ажилласан жил</b>	<b>Тухайн байгууллагад ажилласан жил</b>	<b>Регистрийн дугаар</b>	<b>НДД дугаар</b>
<b>0</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>		<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>

Тайлбар: Энэ маягтанд холбогдох заалтад шаардагдах инженер техникийн ажилтан бүрийн мэргэжлийн диплом, мэргэшлийн зэргийн гэрчилгээ, нийгмийн даатгалын дэвтрийн баталгаажуулсан хуулбар /нүүр, шимтгэл төлсөн бичилт, тушаалын хэсгийн хамт/, гэрээт ажилтны хувьд хөдөлмөрийн гэрээний хуулбарыг хавсаргана.

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/

гарын үсэг

Тэмдэг

**Багаж тоног төхөөрөмжийн тодорхойлолт**

№	Төрөл	Үйлдвэрлэгч	Марк	Хувийн дугаар	Нарийвчлал (өнцөг, зай, байрлал)	Гэрчилгээний дугаар	Баталгаажуулсан огноо
0	1	2	3	4		6	7

Тайлбар: Энэ маягтанд холбогдох заалтад шаардагдах хэмжилт зураглалын багажны шалгалтын гэрчилгээний баталгаажуулсан хуулбарыг хавсаргана.

**Программ хангамжийн тодорхойлолт**

№	Төрөл	Нэр	хувилбар	Лиценз №	Үйлдвэрлэсэн огноо
0	1	2	3	4	

Тайлбар: Энэ маягтанд холбогдох заалтад шаардагдах боловсруулалтын программ хангамжийн үйлдвэрлэгчийн зөвшөөрөл /гэрээ, лиценз/-ийн хуулбарыг хавсаргана.

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/

гарын үсэг

Тэмдэг

## ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ТОДОРХОЙЛОЛТ

*/ИТА бүрт тусад нь хуудас бөглөнө./*

1. Овог нэр:
2. Хийж гүйцэтгэсэн ажлын туршлага:

---

Тайлбар: Энэ тодорхойлолтод холбогдох инженер техникийн ажилтнуудын тухайнзаалтаар хийж гүйцэтгэсэн ажлууд хамрагдана.

Дарга /Захирал/ ..... /Овог нэр/

гарын үсэг

Тэмдэг

**Норм ба стандарт, техникийн баримт бичгийн жагсаалт**

№	Норм ба стандартын нэр	Код	Тоо

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/

гарын үсэг

Тэмдэг

Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагааэрхлэх мэргэжлийн байгууллагын  
эрх олгох журмын гуравдугаар хавсралт

**БАТЛАВ:**

МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ

АЖ АХУЙ НЭГЖИЙГ ТӨЛӨӨЛЖ

ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

АЛБАН ТУШААЛ, ОВОГ, НЭР

АЛБАН ТУШААЛ, ОВОГ НЭР

.....

..... /Гарын үсэг/

/Гарын үсэг/

**..... ТООТ ГЭРЧИЛГЭЭ БҮХИЙ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ**

## ЭЗЭМШИГЧТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

20.. оны ... дугаар сарын ...-ний  
өдөр №....

Улаанбаатар хот

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Газрын тухай тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дах заалт, **Барилга, хот байгуулалтын Сайдын 20... оны .. дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар тушаалыг үндэслэн нэг талаас мэргэжлийн байгууллагын эрх олгогчийг төлөөлж хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын мэргэжилтэн ....., нөгөө талаас мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчийг төлөөлж“.....” ХХК-ний газар зохион байгуулагч, газрын кадастр инженер /ерөнхий инженер .....нар энэхүү гэрээг байгуулав.**

1.2.Энэхүү гэрээний зорилго нь мэргэжлийн байгууллагын эрх олгогч, эзэмшигчийн хооронд үүссэн харилцааг зохицуулах бөгөөд олгогдсон эрхийн хүрээнд хийгдэх газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, газрын нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын үйлчилгээ, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэхэд оршино.

### Хоёр. Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчийн эрх, үүрэг

2.1.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигч нь зөвхөн эрхийн хүрээнд заагдсан заалтаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

2.2.Холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллаж, ажлын үр дүнгээ захиалагчийн өмнө бүрэн хариуцах;

2.3.Захиалгат ажлыг гүйцэтгэхдээ хууль тогтоомж, журам, заавар зөрчсөн болон гүйцэтгэсэн ажил нь заавар, стандартын шаардлага хангаагүй нь тогтоогдвол уг ажлын дутагдал, доголдлыг өөрийн хөрөнгөөр дахин хийж, ажлыг бүрэн гүйцэд хүлээлгэн өгөх;

2.4.Тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээний талаархи дэлгэрэнгүй тайлан мэдээг мэргэжлийн байгууллагын баталсан загварын дагуу тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны дотор Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газарт бичгээр эсвэл [gzbreport@mcud.gov.mn](mailto:gzbreport@mcud.gov.mn) хаягаар цахим байдлаар илгээж гэрээгээ дүгнүүлэн ажиллах ба хугацаа хожигдсон тайланг хүлээн авахгүй;

2.5.Захиалгат ажлыг Монгол Улсад мөрдөж байгаа солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд хийх.

2.6.Байгууллагын удирдлага, хаяг, утас, электрон шуудан, боловсон хүчний болон багаж тоног төхөөрөмжийн өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүр мэргэжлийн байгууллагын эрх олгогч байгуулагад мэдэгдэж байх;

2.7.Мэргэжлийн байгууллагын эрхийн хүрээнд гүйцэтгэх ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар гэрээний үндсэн дээр хийх;

2.8.Гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөхдөө гүйцэтгэсэн газар зохион байгуулагч инженер боловсруулах, хянах шатанд гарын үсгээр зурж, удирдах ажилтан батлах шатанд гарын үсгээ зурж, байгууллагын тэмдэг дарж байх;

2.9.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигч нь эрхийн хугацааг дуусахаас 30 ба түүнээс доошгүй өдрийн өмнө сунгуулах тухай хүсэлтээ **Барилга, хот байгуулалтын яаманд** гаргах.

2.10.Эрхэлсэн ажлын чиглэлээр тендерт оролцох, улсын захиалгат ажил гүйцэтгэх.

2.11.Мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт, семинар зохион байгуулах, үнэлэлт дүгнэлт гаргахад дэмжлэг үзүүлэх.

2.12.Газрын тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээх зэрэг болно.

### **Гурав. Мэргэжлийн байгууллагын эрх олгогчийн эрх, үүрэг**

3.1.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигч этгээдийн үйл ажиллагааны тайлан мэдээг жил бүр хүлээн авч дүгнэх, мэдээллийн санд бүртгэж баталгаажуулах, гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг үйлдэн зөвлөмжийн хамт цахим байдлаар хүргүүлэх ба эх хувийг архивийн нэгж үүсгэн хадгалах;

3.2.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигч этгээдийн хүсэлтийг үндэслэн сонирхогч этгээдэд холбогдох хуульд нийцүүлэн тодорхойлолт гаргаж өгөх;

3.3.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчийн боловсон хүчний чадварыг дээшлүүлэх үүднээс гадаад, дотоодын ижил төстэй ажил, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын туршлагыг судлах, дадлага хийх, үзэсгэлэн семинар зохион байгуулах, оролцоход нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

3.4.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигч этгээдийн үйл ажиллагаанд шалгалт хийж, хуульд заасан арга хэмжээг авах, шалгалтын дагуу ажлын удирдамж, чиглэл өгч байх;

3.5.Аж ахуйн нэгж нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох журамд заасны дагуу арга хэмжээг авах.

3.7 Газрын тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

### **Дөрөв. Бусад зүйл**

4.1.Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж талууд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд гэрээний хүчинтэй байх хугацаа нь шийдвэр гарсан өдрөөс эхлэн эрх олгосон хугацаагаар тодорхойлогдоно.

4.2.Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

*Мэргэжлийн байгууллагын эрх олгогчийг  
төлөөлж:*

/гарын үсэг/  
\_\_\_\_\_

*Мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчийг  
төлөөлж:*

/гарын үсэг/ \_\_\_\_\_

Хаяг:

*Хаяг:*

Утас:

*Утас:*

Факс:

*Имэйл:*

Цахим хуудас

“Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох журмын дөрөвдүгээр хавсралт

### **МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР,**

### **ТОДОРХОЙЛОЛТ**

1.Мэргэжлийн байгууллагын эрх эзэмших этгээдэд олгох гэрчилгээ /цаашид “гэрчилгээ” гэх/-ний загварыг тодорхойлов.

2.Гэрчилгээ нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-4.1.7-д заасныг тусгасан байна.

3.Гэрчилгээний загварыг тодорхойлолтод хавсаргав.

## ГЭРЧИЛГЭЭНИЙ НҮҮРЭН ТАЛ, АГУУЛГА

4.Гэрчилгээ нь А4 форматтай байна.

5.Гэрчилгээний дэвсгэрийг түмэн наст хээгээр дүүргэн, төвд хэсэгт Монгол Улсын хилийг саарал хүрээгээр 105x55мм, соёмбийг цагаан хүрээтэйгээр 70x30мм хэмжээтэйгээр оруулна.

6.Гэрчилгээний хүрээ алтлаг шаргал өнгийн алхан хээтэй байна.

7.Гэрчилгээний дээд төв хэсэгт 18x32 мм хэмжээтэй соёмбо байрлуулах ба MNS6262:2011 стандартад заасан шаардлагыг хангасан байна.

8.Соёмбын доод талд “МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ” гэсэн гарчиг, эрхийн дугаар байна.

9.Мэргэжлийн байгууллагын эрхийн гэрчилгээний дугаарыг 7-н оронтой /00-000/00/ тоогоор тэмдэглэж, ангилал, кодыг оруулах ба 00- аймаг, дүүргийн зипкодны эхний 2 орон, 000- тухайн жилд олгогдож буй эрхийн дугаар, 00- тусгай зөвшөөрөл олгогдсон оныг илэрхийлнэ.

10.Гэрчилгээ нь “*Монгол Улсын Газрын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн...../регистрийн дугаар/-д .....*

заалт

*мэргэжлийн байгууллагын эрхийг ... оны ... дугаар сарын .....-ны өдрөөс ..... жилийн хугацаатай олгов.*

*Мэргэжлийн байгууллагын эрхийн гэрчилгээ нь гэрээний хамт хүчинтэй*

11. ” гэсэн өгүүлбэр бүхий бичвэртэй байна.

12. Гэрчилгээний доод талд гэрчилгээ олгосон Барилга, хот байгуулалтын Сайдын нэр, олгосон огноо, олгосон газрыг бичсэн байна.

## ГЭРЧИЛГЭЭНИЙ АР ТАЛ, АГУУЛГА

13. Гэрчилгээний дээд хэсэгт “СУНГАЛТ” гэсэн үг байх ба түүний доор “.....мэргэжлийн байгууллагын эрхийг

Заалт

..... оны .....дугаар сарын ... өдрөөс эхлэн .... жилийн хугацаатай сунгав.” гэсэн бичвэрийг жижгээр, олгосон “Барилга, хот байгуулалтын Сайд”-ын нэрийг том үсгээр тус тус оруулж бичсэн байна.

14. Гэрчилгээний дунд хэсэгт “Нэмэлт өөрчлөлт” гэсэн бичвэр, түүний доор “.....мэргэжлийн байгууллагын эрхийг

Заалт

..... оны .....дугаар сарын ... өдрөөс эхлэн .... жилийн хугацаатай сунгав.” баталгаажуулсан Барилга, хот байгуулалтын Сайдын нэр, нэмэлт өөрчлөлтийг оруулсан “огноо”-г оруулна.

15. Гэрчилгээнд “Эрх эзэмшигчийн хаяг”, “Утас”, “Факс”, “E-mail” зэргийг тусгаж өгнө.

## СОЁМБО

**БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

**МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ**

**Дугаар**

*Монгол Улсын Газрын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн...../регистрийн дугаар/-д .....*

*заалт*

*мэргэжлийн байгууллагын эрхийг ... оны ... дугаар сарын .....-ны өдрөөс ..... жилийн хугацаатай олгов.*

*Мэргэжлийн байгууллагын эрхийн гэрчилгээ нь гэрээний хамт хүчинтэй*

САЙД

Улаанбаатар

огноо

**СУНГАЛТ**

.....мэргэжлийн байгууллагын эрхийг

Заалт

..... оны .....дугаар сарын ... өдрөөс эхлэн .... жилийн хугацаатай сунгав.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД ..... /гарын үсгийн тайлал/

Огноо

**НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

.....мэргэжлийн байгууллагын эрхийг

Заалт

..... оны .....дугаар сарын ... өдрөөс эхлэн .... жилийн хугацаатай олгов.

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД..... /гарын үсгийн тайлал/

Огноо

**НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

.....мэргэжлийн байгууллагын эрхийг

Заалт

..... оны .....дугаар сарын ... өдрөөс эхлэн .... жилийн хугацаатай олгов.

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД..... /гарын үсгийн тайлал/

Огноо

ЭРХ ЭЗЭМШИГЧИЙН ХАЯГ .....

.....

КОМПАНИЙН ЗАХИРАЛ:

УТАС:

ФАКС:

E-MAIL:

“Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн  
байгууллагын  
эрх олгох журмын тавдугаар хавсралт

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ  
ХОТ БАЙГУУЛАЛТ ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ  
БОДЛОГЫН ГАЗАРТ

Мэргэжлийн байгууллагын тайланг хүргүүлэх тухай

Манай компани нь.... тоот мэргэжлийн байгууллагын эрх эзэмшдэг ба ... оны ... тоот гэрээний дагуу ... оны дэлгэрэнгүй тайланг үнэн зөв, бүрэн бүрдүүлж хавсралтаар хүргүүлэв.

Хянан үзэж, гэрээг дүгнэж өгнө үү.

Байгууллагыг төлөөлж:

албан тушаал \_\_\_\_\_

овог нэр \_\_\_\_\_

ТАМГА

*Байгууллагын албан ёсны хэвлэмэл хуудсыг ашиглах ба хэвлэмэл хуудас нь Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн тушаалаар батлагдсан “ТӨРИЙН АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗААВАР”-ын 2.3.3-2.3.4 дэх шаардлагыг хангасан байна.*

**БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

Огноо: .....оны .....дугаар сарын ...-ны өдөр

.....ХХК-ийн .... ОНЫ тайлан

*Мэргэжлийн байгууллагын эрхийн заалтууд*

.....

ТАНИЛЦСАН:...../ /

ХЯНАСАН:...../ /

БИЧСЭН:...../ /

.....ХуудасТАЙ

*\*Тайланг хянасан нь гэрээгбайгуулсан мэргэжилтэн, танилцсан газрын дарга тус тус байна.*

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН КАДАСТРЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ**

**МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХТЭЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТУХАЙН  
ЖИЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАНГЫН БҮРДЭЛ**

*/Энэ хэсэг нь аж ахуйн нэгжээс ирүүлэх тайлангийн бүрдэлд хамаарахгүй/*

1. Тухайн жилд хийж гүйцэтгэсэн нийт ажлын жагсаалт /хавсралт №2/ ;
2. Шинээр орсон гарсан инженер техникийн ажилчдын жагсаалт /хавсралт №1/;
3. Багаж, тоног төхөөрөмжийн жагсаалт /хавсралт №1/;
4. Ангилсан ажилбар тус бүрээс 1 ажлын зохих бүрдэл /БД 11-106-08-ийн хавсралт/-ийг хангасан техникийн тайлангийн хуулбар хувь эсвэл Газар зохион байгуулалтын улсын нэгдсэн санд баримт хүлээлгэн өгсөн актын хуулбарын нотариатаар баталгаажуулсан хуулбар байна.

Хавсралт № 1

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ

Овсон хүчний мэдээлэл

Удирдах ажилтан

Овог нэр	Мэргэжил	Албан тушаал	Утас	Email	

**Үндсэн ажилтан**

Овог нэр	Регистр	Албан тушаал	Мэргэжил	Дипломны дугаар	Аж
<i>атдорж</i>	<i>Хх00000000</i>	<i>Кадастрын инженер</i>	<i>Газрын кадастр</i>	<i>D2008007</i>	<i>5</i>

**Гэрээт ажилтан**

--	--	--	--	--	--

*\*Энэхүү жагсаалт нь Мэргэжлийн диплом, Нийгмийн даатгалын дэвтэр (нүүр, ажилд орсон тушаал, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бичилтийн хамт)-ийн хуулбар, гэрээт ажилтнуудын ажилд томилсон тушаал, хөдөлмөрийн гэрээний хуулбарын хамт хүчинтэй*

**гаж тоног төхөөрөмж**

**Байрлал болон зайн хэмжилт хийх**

Төрөл	Үйлдвэрлэгч	Марк	Хувийн дугаар	Нарийвчлал (өнцөг, зай, байрлал)	Гэрчилгээний дугаар	Батал
<i>SS</i>	<i>Trimble</i>	<i>R8</i>	<i>12151234</i>	<i>Rtk 10mm+10ppm</i>	<i>№12456</i>	<i>2013.01.</i>

**Өндрийн хэмжилт хийх**


*\*Энэхүү жагсаалт нь багаж баталгаажуулалтын гэрчилгээний баталгаажуулсан хуулбарын хамт хүчинтэй.*

**Боловсруулалтын программ хангамж**

Байрлал, Өнцөг, Зай, GNSS-ийн өгөгдөл боловсруулах

Төрөл	Нэр	хувилбар	Лиценз №	Үйлдвэрлэс
Өгөгдөл боловсруулах	Leica	Geooffice	12151234	2013 он
Бусад				

*\*Энэхүү жагсаалт нь программ хангамжийн үйлдвэрлэгчийн лиценз, эсвэл худалдан авсан тухай гэрээний хуулбарын хамт тус тус ирүүлнэ.*

№	Ажлын нэр	Зориулалт	
<b>Хянан баталгаа</b>			
1			
2			
<b>Газар зохион байгуулалт</b>			
1			
2			
<b>Газрын кадастрын үйл ажиллагаа</b>			
1			
2			

Хавсралт 2

“Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох журмын зургаадугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХТЭЙ АЖ АХУЙН НЭГЖИЙНГЭРЭЭНИЙ .....  
ОНЫ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭСЭН ТЭМДЭГЛЭЛ

Аж ахуйн нэгжийн нэр:	“.....” ХХК		
Гэрээний дугаар:	МБ 20.../..		
Удирдах албан тушаалтан:	..... овогтой.....		
<b>1. Мэргэжлийн байгууллагын суурь нөхцөл, шаардлагын биелэлт</b>			
Инженер техникийн ажилчид			
№	Овог, нэр	Мэргэжил	Албан тушаал
Багаж тоног төхөөрөмжийн баталгаажуулалт			
№	Багажны төрөл, загвар	Баталгаажуулсан эсэх (✓)	
<b>2. Гэрээгээр хүлээсэн бусад үүргийн биелэлт</b>			
№	Заалтууд	Мөрдсөн эсэх (✓)	
1	Холбогдох хууль, журмын заалт		
2	Бусад батлагдсан норм дүрмийн заалтууд		
3	Ажлын нэр	Гүйцэтгэл	
<b>ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛ</b>			

*Аж ахуйн нэгжийн эзэмшигч байгаа мэргэжлийн байгууллагын эрхийн суурь нөхцөл, шаардлага, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдлыг харгалзан үзэж, гэрээний үүргээ хангалттай эсвэл хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэнэ. Аж ахуйн нэгжээс ирүүлсэн тухайн жилд гүйцэтгэсэн ажлын техникийн тайлантай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч болно.*

Тэмдэглэл:

..... ХХК нь гэрээний үүргээ ... онд ..... биелүүлсэн гэж үзэв.

Аж ахуйн нэгжид өгсөн зөвлөмж:

1. ....

2. ....

Танилцсан:

Барилга, хот байгуулалтын яамны

Хот байгуулалт, газрын харилцааны

бодлогын газрын дарга

үсэг /...../

гарын

тэмдэг

Дүгнэсэн:

Барилга, хот байгуулалтын яамны

Хот байгуулалт, газрын харилцааны

бодлогын газрын мэргэжилтэн

гарын үсэг

/...../